


БҮРТГЭСЭН ХАНДАЛТ 528↑ (сүвгаар)

УТСААР
349↑



5.5%	29↑	БИЕЧЛЭН
9.5%	50↓	ВЭБ ХУУДАС
10.2%	54↓	ДУУТ ШУУДАН
4.7%	25↑	И-МЭЙЛ
4.0%	21↑	ЧАТ

Суваг	2024	2025
	09.03	
☎	502	349
👥	22	29
🌐	29	50
📧	6	54
✉	0	25
💬	16	21
#	575	528


Нийт дуудлага
1342↑

Хүлээн авсан дуудлага
349↑

Дуудлага авсан
28.3%↑

eMongolia-д шилжүүлсэн – 107↓
Алдсан дуудлага – 886↑

ХАМГИЙН ОЛОН ХАНДАЛТ АВСАН БАЙГУУЛЛАГА



ХАМГИЙН ОЛОН ХАНДАЛТ АВСАН АСУУДАЛ



ӨНӨӨДРИЙН ОНЦЛОХ 3 АСУУДАЛ

ОНЦЛОХ АСУУДАЛ-1

ХУД-15, “Акуа Гарден” хотхоны асуудлыг хурдан шийдвэрлэх хэрэгтэй байна. НЗДТГ-ын холбогдох албан тушаалтнууд шүүх хуралдаа ирэхгүйгээс үүдэж шүүх хурал олон удаа хойшлогдож, 500 гаруй өрх хохирч байгаад гомдолтой байна. Уг асуудлыг холбогдох газар нь уламжилж, иргэнд хариуг өгч ажиллах талаар

ОНЦЛОХ АСУУДАЛ-2

ХУД-ийн 34 дүгээр сургууль нь 7, 8-р ангийн хүүхдүүдээ уулын оройд газрын мухарт хичээлийн байр түрээсэлж хичээллүүлж байгааг эсэргүүцэж байна. Хичээл орж байгаа өрөө нь цонхгүй ямар ч агааргүй орчны нөхцөл байдал хүнд, багш нар нь хоёр сургуулийн хооронд завсарлагааны 10 минутаар дараагийн хичээлдээ амжиж очиж чадахгүй байна. Нийслэлийн захиргааны байрандаа хэдэн өрөө гаргаад хичээлийг оруулах хэрэгтэй. Эсвэл баригдаж байгаа сургуулийн барилгуудаа яаралтай дуусгаж өгөх талаар

ОНЦЛОХ АСУУДАЛ-3

Нийгмийн даатгалын санхүүжилт олгогдохгүй ажилгүйдлийн тэтгэмж хуваарийн дагуу хугацаандаа олгогдохгүй байгаа асуудлаар иргэд бухимдалтай байгаа талаар

ШИЙДВЭРЛЭЛТ:
346

ХАРИЛЦАХ ТӨВ
11:11

ХАРИЛЦАХ ТӨВ
11:11

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ

- ХУД-23, Яармагт амьдарч буй айлууд хүүхдээ явуулах улсын сургууль алга байна. Одоогийн байдлаар 34 улсын сургууль байгаа бөгөөд нэг ангид 50-аас дээшээ хүүхэдтэй хав харанхуй шахуу подвальд хичээллэж байна. Шинээр баригдаж байгаа сургууль нь 60 хувьтай оноос өмнө ашиглалтад орно гэсэн боловч ороогүй, улсын сургууль баригдаж байгаа ч ашиглалтад орохгүй байгаа тул эцэг эхчүүд хүнд байдалд байна. Хажууд нь олон хувийн сургууль баригдаж дууссан ч, улсын сургууль нь ахиц дэвшил гарахгүй байгаад гомдолтой байна. Яаралтай асуудлыг шийдвэрлэхэд олон эцэг эхчүүд хүлээж байгаа тул холбогдох газарт уламжилж өгнө үү.

❖ **ХУД-15, Нийслэлийн ерөнхий боловсролын 130 дугаар сургуульд харьяаллын дагуу манай 2 хүүхэд сурдаг. 6-р ангид 67 сурагч, 2 дугаар ангид 58 сурагч сурч байна. Суралцах орчин маш хүндрэлтэй, анги танхимын хүрэлцээ сандал ширээ хүрэлцэхгүй 3, 3-аараа сууж хичээллэж байна. Сургуулийн захиргаанд хандахад анги танхимын хүрэлцээ байхгүй гэсэн тайлбарыг өгч байна. Холбогдох байгууллагад нь уламжлан сургуулийн асуудлыг шийдэж өгнө үү.**

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН

- СБД-ийн хүүхэд, гэр бүл хөгжлийн газарт гомдол гаргаж байна. 2025.01.30-ны өдөр шүүгчийн захирамжаар тухайн хэлтсийн шинжээчээр томилсон. Гэтэл өнөөдрийн хүртэл шинжээчийн дүгнэлтийг гаргаж өгөхгүй байна. Лавлаж асуухад холбогдох мэргэжилтнүүд нь ээлжийн амралттай байгаа, удахгүй явуулна гэсэн тайлбар өгч байна. Уг асуудлыг холбогдох газар нь уламжилж, арга хэмжээг авч өгнө үү.
- 2025.02.14-нд МУ-ын ерөнхий аудитор Д.Загджавт Дундговь аймгийн төрийн аудиторын газрын дарга менежер нар удаа дараа ёс зүйгүй үйлдэл гаргаж байна энэ хүмүүст арга хэмжээг авч өгөх талаар өргөдөл гомдол гаргасан. Үндэсний аудитын газраас 03 дугаар сарын 15-нд хариу ирсэн. Ёс зүйн энэ асуудлыг ёс зүйн дэд хороонд шилжүүлэн шалгуулахаар шилжүүлээ гэсэн дотоод албан бичиг ирсэн. Гэвч Ёс зүйн дэд хороо нь өргөдөл гомдлыг хуулийн хугацаа өнгөрсөн байхад шийдэж өгөөгүй байгаад гомдолтой байна. 04 дүгээр сарын 20-ны үед ёс зүйн дэд хорооны нарийн бичиг н.Цэнгүүнтэй холбогдоход манай ёс зүйн хороог хуралдуулах гэхээр зав байхгүй гэсэн тайлбарыг өгч байна. Хуулиа хэрэгжүүлж ажилламаар байна шүү дээ. Гомдлыг холбогдох байгууллагад нь уламжилж өгнө үү.

НИЙГМИЙН ДААТГАЛ

- Албан байгууллагуудын Нийгмийн даатгалын тайланг дараа сарын 5-ны өдөр хүлээж авдаг. Ийм байж яагаад сар гаргаад 5-наас өмнө төлсөн төлбөр тооцоог өмнөх сарын тайлан тооцоонд нь оруулж тайланг төлөгдсөн төлөвтэй болгож болдоггүй вэ. Байгууллагуудын цалингийн зардал ихсэж, багасаж янз янз гарах тохиодол байдаг. Энэ тохиолдолд түрүүлж төлсөн мөнгө дутах мөн сарын сүүлээр албан байгууллагууд мөнгө багатай байх тохиолдлууд байна шүү дээ. Иймэрхүү асуудлуудыг бодож үзэж програмаа сайжруулмаар байна. Хүсэлтийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Мэдээлэл технологийн албанд уламжилж өгнө үү.
- Хөвсгөл аймгийн нийгмийн даатгалын газарт ажилгүйдлийн тэтгэмж 2025.07.29-ний өдөр хүсэлтээ өгөөд баталгаажсан. Гэтэл одоо болтол тэтгэмжээ авч чадахгүй байна. 7509-1000 дугаараас асуухаар 09 дүгээр сард бараг орохгүй, 10 дугаар сард орох байх гэсэн тайлбарыг өгч байна. Хуваарийн дагуу тэтгэмжээ авах хүсэлтэй байгаа тул холбогдох байгууллагад нь уламжилж өгнө үү.

НИЙТИЙН ЭРХ АШИГ ЗӨРЧИГ ДӨЖ БҮЙ

- ХУД-21, "Монгол хаус 2" хотхоны оршин суугч байна. Манай байшингийн ард талаар ТМ-Ялгуун ХХК нь өндөр хүчдэлийн шугам явуулаад байх юм. Оршин суугчдын аюулгүй байдлыг бодсон ч тэр ном журмынх нь дагуу техникийн нөхцөлөө гаргуулаад ажиллаж байгаа эсэх дээр шалгалт хийлгүүлэх хүсэлтэй байна. Уламжилж өгнө үү.
- СХД-1, "Алтан Жолоо Импекс" ХХК ажилчдынхаа авто машиныг хашаандаа тавиулахгүй хашааныхаа гадаа тавиулдаг болсноос хойш ойролцоо амьдарч байгаа оршин суугчид хогоо ачуулж чадахгүй, галын болон түргэний авто машины орц гарц хаагдаж орох боломжгүй болсон, бид өөрсдөө хашаа руугаа орж гарч чадахгүй зэрэг бидний эрх ашиг ихээр зөрчигдөж байна. Ийм байдалтай болоод 1 сар гаруй хугацаа өнгөрлөө. Иймд уг асуудлыг холбогдох газарт нь уламжилж, шийдвэрлэж өгнө үү.

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨН

- Цагдаа нараа ажлаа сайн хийдэг болмоор байна. 1-р эгнээг чөлөөлсөн байхад зөндөө машин 1-р эгнээгээр явж байна. Уг нь замын 1-р эгнээг чөлөөлснөөр автобуснууд саадгүй зорчих ёстой шүү дээ. Холбогдох газар нь саналыг уламжилж өгнө үү.
- БЗД-18, 13 хороолол, 12 байрны хажууд Оюунлаг сургууль байршдаг. Өглөө бүр байрны урд түгжрэл үүсээд замын хөдөлгөөн тэр чигтээ хаагдаад түгжрэл үүсгээд манай байрны оршин суугчдад хүндрэл учруулаад байна. Холбогдох газар нь энэ асуудалд арга хэмжээ авч, зохицуулж өгнө үү.